

**НЬЮБАЛАНС АУДИТ ХХК**



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Хүүхдийн 7 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ХӨА-2023/208/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Мөрөн сум 2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)  
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)  
Нью-баланс аудит ХХК-ний партнер Б.Лхагвадорж  
Утас: 99101901 Цахим хаяг: [newbalance.lhagvaa@gmail.com](mailto:newbalance.lhagvaa@gmail.com)  
Аудитор: П.Мөнхцэцэг  
Утас: 89110535 Цахим хаяг: [munjig\\_123@yahoo.com](mailto:munjig_123@yahoo.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	4
<b>Асуудлыг онцолсон хэсэг</b> .....	4
<b>Аудитын гол асуудал</b> .....	4
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	6
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	16
<b>4.1 Ерөнхий зүйл</b> .....	16
<b>4.2 Материаллаг байдал</b> .....	16
<b>4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт</b> .....	16
<b>4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b>	16
<b>4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт</b> .....	17
<b>4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт</b> .....	17
<b>4.5.1 Завсрын аудитын талаар</b> .....	17
<b>4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал</b> .....	18
<b>5.3 Зөвлөмж</b> .....	18
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	18

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2023.02.24 № 01/2023  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

МӨРӨН СУМЫН ХҮҮХДИЙН 7 ДУГААР  
ЦЭЦЭРЛЭГИЙН ТӨСВИЙН ШУУД  
ЗАХИРАГЧ Д.УНДАРМАА ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мөрөн сумын Хүүхдийн 7 дугаар цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мөрөн сумын Хүүхдийн 7 дугаар цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

2022 онд хувьсах зардлыг улсын төсвөөс, тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн ба улсын төсвөөс 632,644.8 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч 18,177.6 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй, орон нутгийн төсвөөс 143,796.1 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч зарцуулаагүй үлдэгдэл 0,8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

### Аудитын гол асуудал

Боловсролын салбарын шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгож, 2022 оноос санхүүгийн хувьд хагас бие даалгаж, үр дүн, чанар гүйцэтгэлд нь үндэслэн санхүүжүүлэх, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлын санхүүжилт, суралцагчийн сургалтын чанарыг үнэлэх хараат бус тогтолцоо, багшийн ажлын үр дүнг сургалцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого зэргийг багцаар нь шийдвэрлэхээр хууль эрх зүйн актад өөрчлөлт оруулж, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийг ч үр дүнд суурилсан байдлаар хэрэгжүүлэхийг зорьсон байна.

### Бусад асуудлын хэсэг

Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч нь аймгийн Боловсролын газрын даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө хийж, түүнийг хангалттай биелүүлж ажилласан байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А. ЭРДЭНЭБААТАР



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>110,612,731.13</u></b>	<b><u>135,951,168.00</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	18,177,674.25
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	18,177,674.25
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	00.00	18,177,674.25
31211	Төрийн сангийн харилцах	00.00	18,177,674.25
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	1,420,450.00	1,420,450.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	1,420,450.00	1,420,450.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,420,450.00	1,420,450.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	109,192,281.13	116,353,043.75
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	3,132,983.70	2,932,550.37
35130	Эм боох материал	3,132,983.70	2,932,550.37
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	106,059,297.43	113,420,493.38
35410	Бичиг хэргийн материал	660,500.00	130,000.00
35420	Аж ахуйн материал	759,000.00	63,100.00
35460	Хүнсний материал	5,112,042.47	4,850,614.42
35470	Бусад хангамжийн материал	99,527,754.96	108,376,778.96
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>720,664,103.99</u></b>	<b><u>693,940,262.01</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	720,664,103.99	693,940,262.01
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	441,966,603.99	415,242,762.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	450,769,000.00	450,769,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-98,442,550.55	-127,275,384.83
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	69,654,968.54	94,222,041.27
39206	Хуримтлагдсан элэгдэл	-13,239,727.07	-27,796,923.03
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,547,839.63	12,542,288.63
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,236,107.94	-5,850,195.25
39214	Бусад үндсэн хөрөнгө	50,386,920.00	50,386,920.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-27,906,238.62	-34,187,484.78
39217	Ном	2,432,500.00	2,432,500.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	278,697,500.00	278,697,500.00
39301	Програм хангамж	787,000.00	787,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-787,000.00	-787,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	278,697,500.00	278,697,500.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>831,276,835.12</u></b>	<b><u>829,891,430.01</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>6,852,850.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	00.00	6,852,850.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	00.00	6,852,850.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	6,852,850.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>831,276,835.12</u></b>	<b><u>823,038,580.01</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	831,276,835.12	823,038,580.01
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	545,419,997.49	545,419,997.49
51101	Өмч: - төрийн	530,069,997.49	530,069,997.49
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	15,350,000.00	15,350,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-145,545,339.94	-153,726,965.05
51210	Өмнөх үеийн үр дүн	-145,545,339.94	-145,488,709.94
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-8,238,255.11
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	431,402,177.57	431,345,547.57
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>831,276,835.12</u></b>	<b><u>829,891,430.01</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>737,000,166.00</b>	<b>819,885,924.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>22,870,500.00</b>	<b>43,445,024.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	22,870,500.00	43,445,024.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>714,129,666.00</b>	<b>776,440,900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	617,390,600.00	632,644,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	617,390,600.00	632,644,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	2,686,066.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,371,066.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	315,000.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	94,053,000.00	143,796,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	94,053,000.00	143,796,100.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>726,533,671.20</b>	<b>828,085,615.81</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>726,533,671.20</b>	<b>828,085,615.81</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	716,657,551.79	828,084,722.75
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	462,158,090.94	506,011,515.85
210101	Үндсэн цалин	305,615,028.91	368,430,599.55
210102	Нэмэгдэл	112,568,731.03	106,372,796.96
210104	Урамшуулал	43,974,331.00	31,208,119.34
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	59,714,785.14	63,327,415.86
210201	Тэтгэврийн даатгал	41,338,026.27	43,106,090.19
210202	Тэтгэмжийн даатгал	4,594,169.14	5,055,291.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,675,355.12	4,044,172.70
210204	Ажилгүйдлийн даатгал	918,810.65	1,010,981.96
210205	Эрүүл мэндийн даатгал	9,188,423.96	10,110,879.30
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	85,777,726.51	91,715,990.98
210301	Гэрэл, цахилгаан	3,026,046.32	4,491,216.49
210302	Түлш, халаалт	76,637,202.08	76,717,201.88
210303	Цэвэр, бохир ус	6,114,478.11	10,507,572.61
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	19,535,865.84	18,288,850.00
210401	Бичиг хэрэг	439,100.00	6,810,000.00
210402	Тээвэр, шатахуун	220,000.00	275,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,222,700.00	661,750.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,061,566.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,644,100.01	10,542,100.00
210408	Бараа материал акталсны зардал	5,948,399.83	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	29,836,419.10	75,176,271.38
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,785,016.30	176,233.33
210502	Хоол, хүнс	23,051,402.80	75,000,038.05
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,733,400.00	6,450,000.00
210604	Урсгал засвар	6,733,400.00	6,450,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	96,000.00	563,600.00
210702	Дотоод албан томилолт	96,000.00	563,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний</b>	1,919,000.00	00.00

төлбөр, хураамж			
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,199,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>50,886,264.26</b>	<b>66,551,078.68</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	582,000.00	5,748,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,406,900.00	6,466,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	43,897,364.26	54,336,078.68
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>9,876,119.41</b>	<b>893.06</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>1,258,873.49</b>	<b>893.06</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,258,873.49	893.06
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>8,617,245.92</b>	<b>00.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,617,245.92	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>10,466,494.80</b>	<b>-8,199,691.81</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>7,306,900.00</b>	<b>38,563.30</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	38,563.30
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	7,306,900.00	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-7,306,900.00</b>	<b>-38,563.30</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>3,159,594.80</b>	<b>-8,238,255.11</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>714,129,666.00</b>	<b>776,440,900.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>714,129,666.00</b>	<b>776,440,900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>617,390,600.00</b>	<b>632,644,800.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	617,390,600.00	632,644,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>2,686,066.00</b>	<b>00.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,371,066.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	315,000.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>94,053,000.00</b>	<b>143,796,100.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	94,053,000.00	143,796,100.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>683,639,666.00</b>	<b>758,263,225.75</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>683,639,666.00</b>	<b>758,263,225.75</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>673,763,546.59</b>	<b>758,262,332.69</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>460,264,868.94</b>	<b>506,011,515.85</b>
210101	Үндсэн цалин	305,615,028.91	368,430,599.55
210102	Нэмэгдэл	112,568,731.03	106,372,796.96
210104	Урамшуулал	42,081,109.00	31,208,119.34
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>62,021,924.14</b>	<b>63,327,415.86</b>
210201	Тэтгэврийн даатгал	43,645,165.24	43,106,090.19
210202	Тэтгэмжийн даатгал	4,594,169.14	5,055,291.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,675,355.15	4,044,172.70
210204	Ажилгүйдлийн даатгал	918,810.65	1,010,981.96
210205	Эрүүл мэндийн даатгал	9,188,423.96	10,110,879.30

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	85,657,726.51	91,715,990.98
210301	Гэрэл, цахилгаан	3,026,046.32	4,491,216.49
210302	Түлш, халаалт	76,517,202.08	76,717,201.88
210303	Цэвэр, бохир ус	6,114,478.11	10,507,572.61
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	18,800,766.00	00.00
210401	Бичиг хэрэг	689,700.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	340,000.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,222,700.00	00.00
210404	Ном, хэвлэл	353,900.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,241,566.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,952,900.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	29,400,561.00	72,933,710.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,635,500.00	00.00
210502	Хоол, хүнс	24,349,461.00	72,933,710.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,415,600.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	8,296,400.00	7,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,160,000.00	00.00
210604	Урсгал засвар	7,136,400.00	7,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	96,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	96,000.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,919,000.00	1,258,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,199,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	1,258,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	7,306,300.00	16,015,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	582,000.00	11,215,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,724,300.00	4,800,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>9,876,119.41</b>	<b>893.06</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	1,258,873.49	893.06
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,258,873.49	893.06
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	8,617,245.92	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,617,245.92	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>30,490,000.00</b>	<b>18,177,674.25</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>30,490,000.00</b>	<b>00.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>30,490,000.00</b>	<b>00.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	30,490,000.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	30,490,000.00	00.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-30,490,000.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	18,177,674.25
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	18,177,674.25

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	266,722,497.49	106,417,723.52	-108,514,498.03	264,625,722.98
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>266,722,497.49</b>	<b>106,417,723.52</b>	<b>-108,514,498.03</b>	264,625,722.98
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-13,053,238.65	-13,053,238.65
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>545,419,997.49</b>	<b>431,402,177.57</b>	<b>-145,545,339.94</b>	831,276,835.12
D01	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>545,419,997.49</b>	<b>431,402,177.57</b>	<b>-145,545,339.94</b>	831,276,835.12
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	56,630.00	56,630.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>545,419,997.49</b>	<b>431,402,177.57</b>	<b>-145,488,709.94</b>	831,333,465.12
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-56,630.00	00.00	-56,630.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-8,238,255.11	-8,238,255.11
D09	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>545,419,997.49</b>	<b>431,345,547.57</b>	<b>-153,726,965.05</b>	823,038,580.01

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	776,440,900.00	758,262,332.69	18,178,567.31	97.7
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	776,440,900.00	758,262,332.69	18,178,567.31	97.7
210	Бараа, үйлчилгээний зардал	776,440,900.00	758,262,332.69	18,178,567.31	97.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	506,011,700.00	506,011,515.85	184.15	100.0
210101	Үндсэн цалин	398,505,400.00	368,430,599.55	30,074,800.45	92.5

210102	Нэмэгдэл	92,984,900.00	106,372,796.96	(13,387,896.96)	114.4
210104	Урамшуулал	14,521,400.00	31,208,119.34	(16,686,719.34)	214.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,327,500.00	63,327,415.86	84.14	100.0
210201	Тэтгэврийн даатгал	43,106,100.00	43,106,090.19	9.81	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	5,055,300.00	5,055,291.71	8.29	100.0
210203	ҮОМШӨ ний даатгал	4,044,200.00	4,044,172.70	27.30	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,011,000.00	1,010,981.96	18.04	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	10,110,900.00	10,110,879.30	20.70	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	91,716,700.00	91,715,990.98	709.02	100.0
210301	Гэрэл цахилгаан	4,000,000.00	4,491,216.49	(491,216.49)	112.3
210302	Түлш, халаалт	77,616,700.00	76,717,201.88	899,498.12	98.8
210303	Цэвэр, бохир ус	10,100,000.00	10,507,572.61	(407,572.61)	104.0
2105	Нормативт зардал	91,104,300.00	72,933,710.00	18,170,590.00	80.1
210502	Хоол, хүнс	91,104,300.00	72,933,710.00	18,170,590.00	80.1
2106	Эд хогшил худалдан авах	7,000,000.00	7,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	7,000,000.00	7,000,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,258,000.00	1,258,000.00	-	100.0
210806	Мэдээллийн технологийн зардал	1,258,000.00	1,258,000.00	-	100.0
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	16,022,700.00	16,015,700.00	7,000.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,222,700.00	11,215,700.00	7,000.00	99.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,800,000.00	4,800,000.00	-	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	776,440,900.00	776,440,006.94	893.06	100.0
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	632,644,800.00	632,644,800.00	-	100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	632,644,800.00	632,644,800.00	-	100.0
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	143,796,100.00	143,795,206.94	893.06	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	143,796,100.00	143,795,206.94	893.06	100.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	18,177,674.25	(18,177,674.25)	-

62	АЖИЛЛАГСДЫН ТОО	40.00	40.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	18.00	18.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	21.00	21.00	-	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт санхүүжилтийн дансаар орлого хүлээн аваагүй байна.

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

**Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:** Мөрөн сумын Хүүхдийн 7 дугаар цэцэрлэг нь тухайн орон нутагт сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагааг эрхэлж байна. Тус хүүхдийн цэцэрлэг нь 2022 онд “Сайн туршлагаа түгээн дэлгэрүүлэх, хамтран суралцах үйл явцыг идэвхжүүлэн, хүүхэд хөгжлийн үнэлгээг сайжруулж, тэргүүлэх багш нарын оролцоо, манлайллыг нэмэгдүүлэх” гэсэн зорилго тавьж, түүнийгээ биелүүлэхийн тулд 7 зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч нь аймгийн Боловсролын газрын даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө хийж, түүнийг хувь 92% биелүүлж ажилласан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

**Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:** 2022 онд боловсролын салбарт шинэчлэл хийж, түүнийг дэмжсэн төсвийг батлан хэрэгжүүлэхийг зорьсон байна. Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийг 2021 онд өөрчлөн найруулснаар “хувьсах зардал”-ыг улсын төсвөөс санхүүжүүлэх болсон байна. Засгийн газар болон Боловсрол шинжлэх ухааны яамнаас дараах шийдвэрүүдийг гаргасан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Боловсролын салбарт хийж байгаа шинэчлэл, үйл ажиллагаа, төсөв санхүүг дэмжсэн шийдвэрийг Засгийн газар, салбарын яамнаас гаргаж мөрдүүлсэн байна. Тухайлбал:

1. Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор “Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчдад хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн”, “Төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын байршил, хэв шинж, хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүр”, “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал” баталсан байна.
2. Засгийн газрын 2022 оны 10Хүүхдийн 7 дугаар тогтоолоор “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээ” баталсан байна.
3. Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/259 дүгээр тушаалаар “Цэцэрлэг, ерөнхий боловсролын багшийг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамруулах заавар”-ыг баталсан байна.
4. Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дүгээр тушаалаар “төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх хуваарилах заавар”-ыг 1 дүгээр, “багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах заавар”-ыг 2 дугаар, “цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ыг 3 дугаар, “тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх

хуваарилах, санхүүжүүлэх зааврыг 4 дүгээр хавсралтаар тус тус батлан хэрэгжүүлсэн байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу дотоод хяналт хэрэгжүүлэх ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан, тухайн онд нийт 3 удаа дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 1, 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу эрхлэгч 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжээс хяналтыг хэрэгжүүлээгүй тул аудитад ашиглах дотоод аудитын гүйцэтгэл, ажлын үр дүнгийн тайлан зэрэг баримт материал байхгүй байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мөрөн сумын Хүүхдийн 7 дугаар цэцэрлэгийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

**Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар:** Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, боловсролын салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна. Гэхдээ санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Боловсролын яам, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Мөрөн сумын Хүүхдийн 7 дугаар цэцэрлэгийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,385.4 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	18,177.70	18,177.70
Авлага	1,420.40	1,420.40	0.00
Бараа материал	109,192.30	116,353.00	7,160.70
Үндсэн хөрөнгө	720,664.10	693,940.30	-26,723.80
<b>Нийт хөрөнгө</b>	<b><u>831,276.80</u></b>	<b><u>829,891.40</u></b>	<b><u>1,385.40</u></b>
Өр төлбөр	0	6,852.80	6,852.80
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	545,420.00	545,420.00	0.00
Хуримтлагдсан үр дүн	-145,545.30	-153,726.90	-8,181.60
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	431,402.10	431,345.50	-56.60
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b><u>831,276.80</u></b>	<b><u>829,891.40</u></b>	<b><u>1,385.40</u></b>

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, бараа материал данс өмнөх оноос нэмэгдэж, үндсэн хөрөнгө данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө данс 18,177.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.
2. Бараа материал данс өмнөх оноос 7,160.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь бусад хангамжийн материалын үлдэгдэл гол нөлөөг үзүүлсэн байна.
3. Үндсэн хөрөнгө данс 26,723.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 27,650.8 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 6,089.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж устгасан, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 54,336.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 765,310.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс, 151,796.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвийн санхүүжилтээр санхүүжүүлэх дүнг 259,327.0 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөр санхүүжүүлэх дүнг 10,000.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж баталсан байна. Энэ нь улсын төсвөөс авах дүнг их хэмжээгээр бууруулсан нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

Байгууллагын 2022 оны төсвийн сар, улирлын хуваарийг Боловсрол Шинжлэх ухааны сайдын 2022 оны 3 дугаар сарын 24-ны А/105 тоот тушаалаар баталж ирүүлсэн ба тайлант онд төрийн үйлчилгээний ажилчид орон нутгийн төсвөөс улсын төсөвт шилжсэнтэй, мөн өргөн хэрэглээний бараа материалын үнэ өссөнтэй холбоотой Боловсрол Шинжлэх ухааны

сайдын тушаалаар төсөвт 2 удаа зохицуулалт хийгдэж төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулсан байна. Тус өөрчлөлтөөр анх баталсан улсын төсвийг 126,661.4 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийг 2,000.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

Тус цэцэрлэг нь 2022 онд 190 хүүхдийн хүчин чадалтай ажиллаж нэг хүүхдийн нормоор тооцож авах санхүүжилт 505,983.4 мянган төгрөг байх байтал 632,644.8 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.Тайлант онд 126,661.4 мянган төгрөгийн илүү санхүүжилт авсан нь төлөвлөлт үндэслэл муутай төлөвлөгдсөн байна.

Боловсролын салбарын шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгож, үр дүн, чанар гүйцэтгэлд нь үндэслэн санхүүжүүлэх, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлын санхүүжилт, суралцагчийн сургалтын чанарыг үнэлэх хараат бус тогтолцоо, багшийн ажлын үр дүнг суралцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого зэргийг багцаар нь шийдвэрлэхээр хууль эрх зүйн актад өөрчлөлт оруулж, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийг ч үр дүнд суурилсан байдлаар хэрэгжүүлэхийг зорьсон байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 632,644.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 143,796.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлж ажилласан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 632,644.8 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч батлагдсан төсвийн дагуу зарцуулж, 18,177.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, орон нутгийн төсвөөс 143,796.1 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч зарцуулаагүй үлдэгдэл 0,8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 758,262.3 мянган төгрөг буюу 97,6 хувьтай байгаа нь хүүхдийн хоолны зардлын төсвийг 18,170.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө	421,307.30	421,307.20	0.10	100
2	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	114,290.50	114,290.40	0.10	100
3	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	91,104.30	72,933.70	18,170.60	80.6
4	Эрүүл мэндийн үйлчилгээ	1,700.00	1,693.00	7.00	99
5	Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	1,700.00	1,700.00	0.00	100
6	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	2,542.70	2,542.70	0.00	100
7	Нийтлэг үйлчилгээ	45,079.40	45,079.40	0.00	100
8	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	98,716.70	98,715.90	0.80	98.9
	<b>Нийт дүн</b>	<b>776,440,9</b>	<b>758,262.30</b>	<b>18,178.60</b>	<b>97.6</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус Хүүхдийн цэцэрлэг нь 2022 онд нэмэлт санхүүжилтийн дансаар орлого хүлээн аваагүй байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мөрөн сумын Хүүхдийн 7 дугаар цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ньюбаланс аудит ХХК-ний ахлах аудитор П.Мөнхцэцэг гүйцэтгэж, хяналтыг Ньюбаланс аудит ХХК-ийн захирал Б.Лхагвадорж анхан шатанд хянаж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Мандахнаран, аудитын менежер Б.Тэгшдэлгэр нар хоёр дахь шатанд, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар дараагийн шатанд хяналтыг хэрэгжүүлсэн.

Мөрөн сумын Хүүхдийн 7 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ньюбаланс аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 726,533.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 14,530.6 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг дүнг 11,624.5 мянган төгрөгөөр тооцсоныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно. Тус байгууллагад дэд болон орлогч даргын орон тоо бүтэц, орон тоонд нь батлагдаагүй, албан тушаалын автомашин байхгүй байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Хүүхдийн 7 дугаар цэцэрлэгийн 2022 оны шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавьсан мэдээллийг хянаж үзэхэд дараах зөрчил илэрч байна. Үүнд:

1. 2022 онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт нийт 148 мэдээлэл оруулахаас 3 мэдээлэл огт мэдээлээгүй, 143 мэдээлэл хугацаандаа мэдээлж, 2 мэдээллийг оруулах хугацаа болоогүй байна.
2. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зардлын гүйлгээг мэдээлсэн байдлыг хянахад зарлагын 35,032.6 мянган төгрөгийн 4 мэдээлэл, орлогын 51,579.7 мянган төгрөгийн 2 мэдээлэл тус тус мэдээлээгүй, орлогын 110,268.1 мянган төгрөгийн 7 гүйлгээг буруу дүнгээр мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.4.5, дахь заалттай нийцэхгүй байгаа ба “нийцсэн бөгөөд зохистой” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх насны боловсролын тухай хуулийн холбогдох заалт, 2022 онд шинээр хэрэгжиж эхэлсэн журам заавруудын хэрэгжилтийг хянаж үзэхэд зөрчил илрээгүй болно.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Мөрөн сумын Хүүхдийн 7 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 2 зөвлөмж өгснөөс Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0	0	0	0
Албан шаардлага	0	0	0	0	0
Зөвлөмж	2	40,5	1	40,5	50
Нийт дүн	2	40,5	1	40,5	50

/мянган төгрөгөөр/

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал байхгүй байна.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайлангийн аудитаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй болно.

Аудитаар нийт 198,685.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил<sup>1</sup> илрүүлж, 196,880.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1,804.9 мянган төгрөгийн 1 зөвлөмж тус тус хүргүүлсэн болно.

##### 5.2 Албан шаардлага

Тус цэцэрлэг нь өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар зөвлөмж авсан мөн тайлант онд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зардлын гүйлгээг мэдээлсэн байдлыг хянахад зарлагын 35,032.6 мянган төгрөгийн 4 мэдээлэл, орлогын 51,579.7 мянган төгрөгийн 2 мэдээлэл тус тус мэдээлээгүй, орлогын 110,268.1 мянган төгрөгийн 7 гүйлгээг буруу дүнгээр мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.4.5, дахь заалттай нийцэхгүй байгаа ба “нийцсэн бөгөөд зохистой” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Бусад хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

###### Илрүүлэлт:

Тайлант онд хүүхдийн хоолны зардалд 18,170.6 мянган төгрөг зарцуулагдаагүй үлдсэн байхад 1,804.9 мянган төгрөгийн өрийн үлдэгдлийг тооцоо нийлж өрөө төлөөгүй байгаа нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6 дах заалттай нийцэхгүй ба “нийцсэн бөгөөд зохистой” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### Өгсөн зөвлөмж:

Авлага, өглөгийн ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах, хариуцагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах, төлөх ажлыг зохион байгуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа	Мэдээллийг тусгахгүй	Буруу тусган илэрхийлсэн	Үүнээс	Зөвлөмж
-------------------	------------	----------------------	--------------------------	--------	---------

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

			орхигдуулсан				Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Дүн	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
			Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
Тоо			Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо
Өглөг үүсгэж ажилласан	1	1,804.9	0	0	0	0	1	1,804.9			0	0
Дүн	1	1,804.9	0	0	0	0	1	1,804.9	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
Тоо			Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хугацаа хоцроож мэдээлсэн	0	0	0	0	1	196,880.5	0	0
Мэдээлээгүй	6	86861263	0	0			0	0
Буруу дүнгээр мэдээлсэн	8	110,268.2	0	0			0	0
Дүн	14	196,880.5	0	0	1	196,880.5	0	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
	0	0	0	0	0	0	0	0
Дүн	0	0	0	0	0	0	0	0
Нийт дүн	14	196,880.5	0	0	1	196,880.5	0	0

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:  
 ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
 АНХАН ШАТАНД ХЯНАСАН:  
 АУДИТЫН МЕНЕЖЕР  
 АУДИТОР  
 НЬЮБАЛАНС АУДИТ ХХК-ИЙН  
 ЗАХИРАЛ ПАРТНЕР



А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО: 11/04

Л.МАНДАХНАРАН ОГНОО: 11/04

Б.ЛХАГВАДОРЖ ОГНОО 2023.02.23



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 10 өдөр

№ 14/НЭЭВӨЧЗЭ/ХАА-2022/008/  
НА-СТА-ТШЗ

Мөрөн сум

### Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Мөрөн сумын Хүүхдийн 7-р цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 148 мэдээлэл оруулахаас 3 мэдээлэл огт мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш зарлагын 4 гүйлгээ, орлогын 2 гүйлгээг мэдээлээгүй, орлогын 8 гүйлгээг буруу дүнгээр мэдээлж 196,880,503.00 (нэг зуун ерэн зургаан сая найман зуун наян мянга таван зуун гурван) төгрөгийн зөрчил гаргасан байна.
2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр; 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэж заасныг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, акт тогтоох журмын 4.2.1.10-т “Аудитаар илэрсэн алдаа зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй”, 4.2.1.11-т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх нөхцөл болно” гэж заасныг тус тус үндэслэн

### ШААРДАХ нь:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2023 оны 9 дугаар сарын 01-ний дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> ирүүлэх;
2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мөрөн сумын Хүүхдийн 7-р цэцэрлэгийн эрхлэгч Д.Ундармаа, нягтлан бодогч Х.Баасандулам нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  А.ЭРДЭНЭБААТАР

АУДИТОР:  Б.ЛХАГВАДОРЖ

<sup>1</sup> Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЭДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас: 70384043



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 08 сарын 20 өдөр

№ 14/АХСБОН29/ХӨА-2023/009-  
НА-ГТА-ТНЗ

Мөрөн сум

### Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Мөрөн сумын Хүүхдийн 7-р цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 148 мэдээлэл оруулахаас 3 мэдээлэл огт мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш зарлагын 4 гүйлгээ, орлогын 2 гүйлгээг мэдээлээгүй, орлогын 8 гүйлгээг буруу дүнгээр мэдээлж 196,880,503.00 (нэг зуун ерэн зургаан сая найман зуун наян мянга таван зуун гурван) төгрөгийн зөрчил гаргасан байна.
2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.


Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр; 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэж заасныг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журмын 4.2.1.10-т "Аудитаар илэрсэн алдаа зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй", 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх нөхцөл болно" гэж заасныг тус тус үндэслэн

#### ШААРДАХ нь:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2023 оны 9 дугаар сарын 01-ний дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> ирүүлэх;
2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мөрөн сумын Хүүхдийн 7-р цэцэрлэгийн эрхлэгч Д.Ундармаа, нягтлан бодогч Х.Баасандулам нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР  
АУДИТОР  Б.ЛХАГВАДОРЖ

<sup>1</sup> Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас: 70384043